



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 01.

Урт

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Хурлын дарга / Б.Отгонбаяр/, Тэргүүлэгчид, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



Гурвантэс сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 07 тоот тогтоолын хавсралт

ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2017 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 он.

Урт.

№	Хийгдэх ажлууд	Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар												Хариуцах эзэн		
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	ИТХурлын үзэл баримтлал, Засаг даргын Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилт, үр дүнг нь иргэдэд байнга мэдээлэх, үнэлэлт дүгнэлт өгөх															ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид
2	ИТХурлын хороодын ажлын төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх															ИТХ-ын хороод
3	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг сонгогдсон тойрогт нь ажиллуулах, багийн хурал, мал тооллого болон нэгдсэн арга хэмжээнүүдэд оролцуулж хийсэн ажлын үр дүнг тооцож ажиллах															ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
4	Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарч, байгууллага, мэргэжилтнүүдийн тайланг хэлэлцэж зөвлөмж өгөх /төлөвлөгөө гаргах/															ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
5	ИТХурлаас шийдвэр гаргахад шаардагдах судалгааг шинэчилж, баяжуулах															ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг шинэчлэх, зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, иргэдэд сурталчлах															ГХУСАЗСЗөвлөл
7	Сум хөгжүүлэх сан, МАК сангийн ажлын тайланг Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж зөвлөмж өгөх															ИТХ-ын тэргүүлэгчид

8	Сумын Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг аймгийн болон Төрийн дээд шагналд тодорхойлох																		ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
9	БИНХурлын дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, ажлын үр дүнг тооцож ажиллах																		ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
10	Сум орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг ИТХурлын нэрэмжит шагналаар шагнаана.																		ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
11	Улаан загалмайн ажлыг иргэдэд сурталчилж сумын нийт өрхийн 40%-ийг татварт хамруулан төвлөрүүлэх																		ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
12	Үйл ажиллагаандаа иргэдийн санал бодлыг тусгах, тэдний тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор сар бүрийн тогтмол өдөрт иргэдийн хүлээн авч уулзах "Өглөөний цай" уулзалтыг зохион байгуулж хэвших																		ИТХ-ын дарга
13	Орон нутгийн төсвийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлд хяналт тавих																		Иргэдийн хурлын төлөөлөгчид
14	Хөрш зэргэлдээ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Энзээ хошуутай хамтын ажиллагааг өргөжүүлж хамтран ажиллана.																		ИТХ-ын дарга
15	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон хэрэгжилтийг хэлэлцэн батлах, гүйцэтгэлд хяналт тавих																		Иргэдийн хурлын төлөөлөгчид

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд

1	Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн саналд тулгуурлан орон нутагт шаардлагатай дүрэм, журам боловсруулж батлан мөрдөж хэрэгжилтэнд хяналт тавина																		ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих																		ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
3	Төрийн үйлчилгээний байгууллагууд ард иргэдэд үйлчилж буй байдалд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо

4	Сумын Засаг даргын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
5	Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар хийгдэж буй ажилд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
6	Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажилд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
7	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан газрууд ажилтнууддаа хууль эрх зүйн мэдээлэл өгөх, хуулийн сан бүрдүүлэх, ард иргэдийн хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
8	Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд гаргасан ергедөл, гомдлыг шийдвэрлэсэн байдалд хяналт тавих																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
9	Тост, тосон бумбын нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийг тогтоолгох																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо

Гурав.Сургалт, Сурталчилгааны талаар.

1.	ЗДТГазартай хамтран нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах, хууль сурталчлах зорилгоор хуулиудын заалтаар анхааруулга, санамж, зөвлөмж хийж иргэдэд сурталчлах																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар
2.	Хурал, Хуралдааны үйл ажиллагаа, Төлөөлөгчдийн ажлын үр дүнгийн талаар тойргийн сонгогчдод мэдээлнэ.																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид
3.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллага, иргэдийн дунд хууль сурталчлах "Иргэн ба хууль" арга хэмжээг зохион байгуулах																		ИТХ-ын дарга, бичгийн дарга, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
4.	Иргэний танхимыг тохижуулж тоног төхөөрөмжөөр хангах, байнгын үйл ажиллагаатай болгох, иргэдийн санал бодлыг сонсон иргэдийг байнгын мэдээллээр хангаж, иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг																		ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, хурлын хороод

	шийдвэрлэж холбогдох байгууллагуудад уламжлах, хэлэлцүүлүүдийг зохион байгуулах																		
5	Архидан согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах																		
6	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтанд хамруулах																		

Дөрөв. Хяналт шалгалт, сахилга дэг журмын талаар.

1.	Сумын урт болон дунд хугацааны төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих																		
2	Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтарч ажиллах																		
3	Сум хөгжүүлэх сангийн зөвлөл болон хяналтын зөвлөлийг шинэчлэн баталж үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах																		
4	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг идэвхжүүлэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих																		
5	Санхүүгийн ил тод байдлыг хангах Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих																		
6	Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зөвлөлийг байгуулж, хийгдэж байгаа хөрөнгө оруулалтуудад явцын хөндлөнгийн хяналтыг хийж гүйцэтгэлийг сайжруулахад анхаарах																		

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 02

Урт

Г Ажилчдын орон тоо, цалингийн сан Г
тогтоох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилчдын орон тоо, цалингийн санг хавсралт 1, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд улиралд нэг удаа олгох урамшуулал, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сар бүр олгох урамшууллыг хавсралт 2 ёсоор тус тус баталсугай.

2. Уг тогтоолд заагдсан ажилчдын Үндсэн цалин, нэмэгдэл урамшууллыг тухай бүр тооцож олгохыг Нягтлан бодогч ~~Н.Цэнгэлмаа~~ д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 03

Урт

Зөвлөл шинэчлэн батлах тухай

Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16-р зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Үүнд: Зөвлөлийн дарга- Б.Отгонбаяр /Хурлын дарга /

Орлогч даргад - О.Баттогтох /Сумын Засаг дарга/

Гишүүдэд: З.Оюунцэцэг /Эрүүл мэндийн төвийн эрхлэгч/

Ц.Энхзул /ЕБС-ийн нийгмийн ажилтан/

М.Мөнхбархас /ЗДТГ-ын нийгмийн ажилтан/

О.Батмөнх /Гоёт багийн Засаг дарга/

Н.Чинбат /Баясах багийн Засаг дарга/

Н.Галаахүү /Тост багийн Засаг дарга/

Л.Пүрэвдорж /Урт багийн Засаг дарга/

Ц.Ганбаатар /Иргэний төлөөлөл/

Нарийн бичгийн даргад- Л.Далайжаргал /Сумын хэсгийн төлөөлөгч/

2. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг тогтмолжуулж, зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг Зөвлөлийн дарга /Б.Отгонбаяр/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01-р сарын 22-ны өдрийн № 04 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.ОТГОНБАЯР





**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 04

Урт

Шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг шинэчлэн батлах тухай

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын албан байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга Ж.Мөнхбаяр /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч/

Гишүүдэд: Н.Энхмандах /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч/

Д.Гантулга /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч/

2. Байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж тайланг сар бүрийн 15-ны дотор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд бичгээр ирүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Ж.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 сарын 22-ны өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.



ХУРЛЫН ДАРГА Б.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 05

Урт

Амьжиргааг дэмжих зөвлөлийг
шинэчлэн батлах тухай.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27,2 дахь хэсгийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.
Үүнд: Зөвлөлийн дарга Д.Гантулга /Засаг даргын орлогч/
Гишүүд: Б.Майхүү /Нийгмийн даатгалын байцаагч/
Ч.Баттогтох /Төрийн бус байгууллагын төлөөлөл/
Л.Жаалхүү /Төрийн бус байгууллагын төлөөлөл/
М.Мөнхбархас /Иргэний төлөөлөл/
Н.Дэлгэрмаа /Иргэний төлөөлөл/

Нарийн бичгийн дарга Н.Цэрэннадмид /Нийгмийн халамжийн мэргэжилтэн/

2. Хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтийн дагуу нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг оновчтой сонгон хамруулж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

3. Зөвлөлийн ажлын үр дүн, тайланг жилийн эцэст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн дарга /Д.Гантулга/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 06 сарын 15-ны өдрийн 18 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 06

Урт

Төрийн дээд шагналд
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22-р зүйлийн 22.1.15 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын Баясах багийн Засаг дарга Думжидын Айлтгүйг төрийн дээд шагнал **“Алтан гадас”** одонгоор, “Хөгшөө” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Лхагвын Төмөртогтохыг **“Хөдөлмөрийн хүндэт”** медалиар шагнуулах саналыг дэмжсүгэй.

2. Шагнуулахаар тодорхойлсон материалыг холбогдох дээд байгууллагад уламжлахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР